



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/54

Мөрөн сум

Сэтгэл зүйчдийн багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, 8 дугаар зүйлийн 8.2.7, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.2, 10.2.7, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дэх заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Амар тайван, аюулгүй орчин” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд, “тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд ажиллах сэтгэл зүйчдийн багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай.

2. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд, иргэд, хүүхэд, залуучуудын сэтгэл зүйн онцлогт тохирсон нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах сэтгэл зүйчдийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Багийг удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр) нарт тус тус даалгасугай.

4. Сэтгэл зүйчдийн багт ажиллахаар сонгогдсон албан хаагчдыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хүрээнд ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг холбогдох төрийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/183 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 7010252

Аймгийн Засаг даргын 2023 оны 02
дүгээр сарын 07-ны өдрийн А/5.4..
дугаар захирамжийн хавсралт



СЭТГЭЛ ЗҮЙЧДИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч: Ц.Нарангэрэл (Мөрөн сумын "Авьяас" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч)

Гишүүдэд:

- | | |
|----------------|--|
| М.Бүдханд | (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) |
| Т.Номин-Эрдэнэ | (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн Сэтгэл зүйч) |
| С.Содномбямба | (Нэгдсэн эмнэлгийн Сэтгэл зүйч) |
| А.Бямбасүрэн | (Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын Архивын ажилтан) |
| Ц.Нарангэрэл | (Мөрөн сумын "Авьяас" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч) |
| С.Ренчиндорж | (Мөрөн сумын "Гурван-Эрдэнэ" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч) |
| Б.Маралгоо | (Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч) |
| Н.Энхдөлгөөн | (Мөрөн сумын "Титэм" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч) |
| С.Бүжлхам | (Мөрөн сумын "Эрдмийн далай" ерөнхий боловсролын сургуулийн Сэтгэл зүйч) |
| Г.Энхтуяа | (Ахмад настны арамж үйлчилгээний төвийн сэтгэл зүйч) |
| Б.Уранбайгаль | (Сэтгэл судлаач) |
| Ш.Амарсанаа | (Хөвсгөл аймаг дахь Политехникийн коллежийн сэтгэл зүйч) |

Нарийн бичгийн дарга:

Д.Эрдэнэтуяа (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)